

УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН НИСЛЭГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУРЫН УЛСЫН СҮЛЖЭЭ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.АМГАЛАНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
(6-12 сар)

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. Улсын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, хяналт тавих							
1	Арга хэмжээ 1.1 Хөдөө аж ахуйн цаг уурын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах арга хэмжээг авах, хяналт тавих	Шинжилгээний ажил тасралтгүй, хэвийн ажиллана		Шинжилгээний ажил тасралтгүй, хэвийн ажиллана. Гарсан асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэсэн байна.	Өнөөгийн ажлын явцын тандан судалгааг Орон нутгийн инженерүүдтэй цахим уулзалт 7 дугаар сард хийсэн. Төсөв хүндрэлтэй тул 8 сард хийх төлөв байдлын ажиглалт тасрах хүндрэл гарсныг Онцгой байдлын газраар энэ жилийн ажиглалтын санхүүг дэмжүүлэхээр болж хөтөлбөрт ажиглалт хэвийн явагдсан. Хөтөлбөрт ажлууд хэвийн. Багаж, хэмжих хэрэгслийн захиалга санхүүгийн төсөв татагдсан тул 2025 оны нийлүүлэлт хийгдээгүй.	6-12	100 90
2	Арга хэмжээ 1.2 Хөдөө аж ахуйн цаг уур, нислэгийн 2026 оны дэвтэр, хүснэгтийн захиалга, хуваарь гаргаж батлуулах, хүлээн авах	Батлагдсан хуваарь гарна.		ХАА, нислэгийн шинжилгээний ажлын дэвтэр, хүснэгт хүлээн авч, тараагдсан байна.	Орон нутгийн хөдөө аж ахуй, нисэхийн инженерүүдээс 2026 онд шинжилгээний ажилд хэрэглэх дэвтэр, хүснэгтийн захиалгыг аймаг тус бүрээр, бусад салбарууд /ус, орчин, цаг уур, нисэх/-тай нэгтгэж нэгдсэн хуваарь гаргаж батлуулсан. Хэвлэлийн компанид 9 хэвлэлийн эхийг хянаж баталгаажуулсан. 12 дугаар сарын 5-нд захиалгын тоо болон хэвлэлийн чанарыг шалгаж хүлээн авсан. Орон нутгуудад бүрэн тараагдсан.	10-12	100 100

3	Арга хэмжээ 1.3 Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын болон аэрологийн шинжилгээний ажлын хөтөлбөрт өөрчлөлт оруулж, шинэчилсэн төслийг боловсруулж, батлуулах	Төсөл гарсан байна	Нэгдсэн хөтөлбөр2016, бэлчээр/ таримал хөтөлбөр2020 онд батлагдсан	Төсөл гарсан байна	2016, 2020 оноос хойш хөтөлбөрт зарим нэг өөрчлөлт орсон тул шинэчлэх шаардлага үүссэн. 2016 оны хөтөлбөрийн 1, 4, 9,10, 11, 12 хавсралтуудад оруулах өөрчлөлтөөр Орон нутаг болон хүрээлэнгийн хөдөө аж ахуйн хэлтсийн ажилтануудаас санал авсан. Хөдөө аж ахуй зарим ажиглалтууд хасагдаж, зарим ажиглалтуудыг дэлгэрэнгүй оруулж шинэчилсэн. Шинэчлэгдсэн хөтөлбөрийн төслийг яамд хүргүүлсэн, 12 дугаар сардаа багтаж батлагдана.	10-12	100 90
4	Арга хэмжээ 1.4 Нарны цацрагийн ажиглалтын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, хяналт тавих	Шинжилгээний ажил хэвийн явагдсан байна.	17 нарны цацрагийн ажиглалтын сүлжээ	Шинжилгээний ажил хэвийн явагдсан байна.	Өнөөгийн ажлын явцын тандан судалгааг Орон нутгийн инженерүүдтэй цахим уулзалт 7 дугаар сард болон хүрээлэнгийн нарны салбар хариуцсан инженертэй биечлэн уулзаж хамтарч ажиллах чиглэл өгсөн. 17 нарны ажиглалтын сүлжээний хөтөлбөрт ажлууд хэвийн. 11 дүгээр сард Архангай актинометрийн багаж эвдэрч багажийн инженерийн дүгнэлтээр акталсан. Шар шороон шуурганы автомат багажийн нарны цацрагийн хэмжилтийг нарны цацрагийн сүлжээний хөтөлбөрт оруулж 19 болсон. Архив мэдээллээр үйлчлэх боломжтой. 2026 оны багаж, хэмжих хэрэгслийн захиалга төсөвийн таналтаас болж хасагдсан.	6-12	100 40
5	Арга хэмжээ 1.5 Аэрологийн шинжилгээний өртөө байгуулах ажлыг Өвөрхангай, Говь-Алтай аймагт зохион байгуулж, хяналт тавих, зарцуулалтын тайлан нэгтгэх	Шинжилгээний ажил тасралтгүй, хэвийн ажиллана Шинээр байгуулагдсан өртөөний тоо		Шинжилгээний ажил тасралтгүй, хэвийн ажиллана. Гарсан асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэсэн байна.	Говь-Алтай аймгийн УЦУОШТ-д БНХАУ-ын Цаг уурын газрын буцалтгүй тусламжаар 2025 оны 07-10 дугаар сард өндрийн агаар мандалын цаг уурын хэмжилт /аэрологи/ хийдэг тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлыг дуустал байнгын хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Цахилгааны 380В холболт болон антен суулгах Хятадын мэргэжилтэн ирэхээр төлөвлөсөн хугацаагаа хойшлуулсан шалтгаанаар хөөргөлт хийгдээгүй. Өвөрхангай аймгийн УЦУОШТ-д БНСУ-ын Цаг уурын газрын буцалтгүй тусламжаар	6-12	100 K

					<p>аэрологийн тоног төхөөрөмж шинээр суурилуулж дууссан. 2025 оны 11 дүгээр сард БНСУ-ын Цаг уур газраас холбогдох мэргэжилтэнүүд ирж туршилтын 2 удаагийн хөөргөлт амжилттай хийсэн. Цаашидаа хөөргөлт хийхэд бэлэн болсон. Солонгосын талаас нийлүүлэх зарим сэлбэг дутуу тул Төслийн хугацааг 2026 оны 4 дүгээр сар хүртэл сунгасан. Иймд Төслийг албан ёсоор хаагаагүй тул хөөргөлтийг хөтөлбөрийн дагуу хөөргөх боломжгүй байна. Аэрологийн улсын сүлжээ нэмэгдснээр урьдчилан мэдээллэх мэдээний таарц сайжирна.</p> <p>Өмнөговь аймгийн аэрологийн хуучин системийг шинэ системээр шинэчилсэн ажил амжилттай явагдсан.</p> <p>Аэрологийн 4 өртөөдийн сар бүрийн зарцуулалтын тайланг хүлээн авч нэгтгэж шаар, зонд, төмрийн үртэс, натри хяналт тавьж 2026 оны нөөц тооцоо гаргасан.</p>		
6	Арга хэмжээ 1.6 Судалгаа, бэлтгэл ажил, Мета мэдээллийн жагсаалт гаргах	Өртөөдийн мета мэдээлэл цахимд орсон эсэх	Архив мэдээллийн сан https://archive.weather.gov.mn	Өртөөдийн мета мэдээлэл цахимд орно	<p>Мета өгөгдлийн сан байгуулах тандан судалгаагаар ДЦУБ-ын OSCAR/Surface платформын мэдээллийн дагуу бэлтгэж Архив мэдээллийн сангийн https://archive.weather.gov.mn/ цахимд өртөөдийн байгуулагдсан он, өндөр, бүсийн дугаар, уур амьсгалын ангилал зэрэг мета мэдээллийг нэмснээр хэрэглэгчид тухайн өртөөний 7 мета мэдээлэл харах боломж бий болсон.</p>	5-12	100
7	Арга хэмжээ 1.7 Хөдөө аж ахуйн салбарын Мэргэшлийн 1, 2, 3-р зэргийн шалгалтын асуултууд бэлтгэх, ажлын хэсгийн хуралдаанд оролцох	Асуултын тоо		Шалгалтын 100 асуултууд гарсан байна.	<p>12 дугаар сарын 4-нд хуралдаанд оролцож ирсэн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэхэд санал өгсөн. Холбогдох заавруудаас 100 асуулт боловсруулж ажлын хэсгийн даргад хүргүүлсэн. Шалгалтын төстийг орон нутгийн техникчдийн мэргэшлийн шалгалтад ашиглана.</p>	12	100

8	Арга хэмжээ 1.8 Олон улсын нислэгийн ICAO-ийн шалгалтын бэлтгэл ажил хангах ажлыг зохион байгуулах	Хэрэгжилт хувиар			НЦУТ-ийн 01/151 тоот албан бичгийн дагуу 2024 оны нисэхийн үйлчилгээний ажлын талаар мэдээлэл гаргуулж тандан судалгаа хийж гарсан хүндрэл, зөрчлийг арилгах, сайжруулах талаар санал солилцсон. Нисэхийн ажилтануудын сургалт, ур чадварыг үнэлэх мэргэшлийн үнэмлэх олгох журамтай танилцаж санал өгсөн, А/236 тушаалаар батлагдсан. ICAO-ийн урьдчилсан шалгалтын дүгнэлт зөвлөмжийн дагуу заавал орчуулах заавар, дүрмийн орчуулгыг хянах ажлын хэсэгт орж 200 хуудастай орчуулгыг хянасан.	11-12	100 ✓
Зорилт 2. ДЦУБ-ын ажиглалтын WIGOS/OSCAR/Surface сүлжээнд цаг уурын ажиглалтын бүх өртөөний мета өгөгдлийг оруулж шинэчлэх							
9	Арга хэмжээ 2.1 Мета өгөгдлийн уур амьсгалын ангилалыг Коппены аргаар тодорхойлох	Зааварчилга гарсан байна		Зааварчилгаа гарсан байна.	ДЦУБ-ын https://oscar.wmo.int/surface/#/ Платформд заасан дагуу уур амьсгалын бүсийг Коппены ангилалаар тодорхойлох ёстой байдаг. Иймд Коппены ангилалыг орчуулж орон нутгийн мэдээлэл үйлчилгээ хариуцсан инженерүүдэд аниллын зааварчилгаа, жишээг гаргаж FTP-гээр хүргүүлсэн.	1-12	100 ✓
10	Арга хэмжээ 2.2 Уур амьсгал /УА/-ын ангилалыг бүх өртөө, харуулаар гаргах	318 өртөө, харуулаар тодорхойлсон байна.		Ангилал хийсэн жагсаалт гарна	Орон нутгийн мэдээлэл үйлчилгээ хариуцсан инженер нарт УА-ын ангилал хэрхэн хийх талаар цахим уулзалтаар болон файл, жишээгээр зааварчилгааг тухай бүрт өгч 317 өртөө, харуул /Хан-Уул өртөө цувааны урт хангалтгүй/-аар 4 ангилалаар тодорхойлсон жагсаалтыг хянаж баталгаажуулсан.	1-12	100 ✓
11	Арга хэмжээ 2.3 Коппены ангилалаар тархалтын зураг гаргах	Тархалтын зураг гарна		Ангилалын газрын зураг гарна	ArcGIS хэрэглээний программыг ашиглан уур амьсгалын 4 ангилалаар тархалтын газрын зураг гаргасан. Газрын арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр 12 дугаар сард хүргүүлсэн. Энэхүү уур амьсгалын ангилалаар хэрэглэгчдэд мэдээгээр үйлчлэх, судалгаанд ашиглах боломжтой.	1-12	100 ✓
12	Арга хэмжээ 2.4	Өртөөдийн мета мэдээлэл	Архив мэдээллийн сан	Өртөөдийн мета мэдээлэл цахимд орно	Мета өгөгдлийн сан байгуулах тандан судалгаагаар ДЦУБ-ын OSCAR/Surface платформын мэдээллийн дагуу бэлтгэж	5-12	100

	Цаг уурын өртөө, харуулын мета мэдээллийг үүсгэх	цахимд орсон эсэх	https://archive.weather.gov.mn		Архив мэдээллийн сангийн https://archive.weather.gov.mn/ цахимд өртөөдийн байгуулагдсан он, өндөр, бүсийн дугаар, уур амьсгалын ангилал зэрэг мета мэдээллийг нэмснээр хэрэглэгчид тухайн өртөөний 7 мета мэдээлэл харах боломж бий болсон.		
13	Арга хэмжээ 2.5 Орон нутгийн мэдээлэл үйлчилгээний ажлын хагас болон жилийн тайланг авч дүгнэх	Тайлан дүгнэж үнэлсэн дүн гаргасан байна.	2024 оны дүн 100	Дүгнэгдсэн байна.	Орон нутгийн мэдээлэл үйлчилгээний ажлын хагас, бүтэн жилийн тайлангуудыг хүлээн авч үнэлэсэн. Дүнг 12 дугаар сарын сүүлээр нэгтгэж гаргана.	6, 12	100
14	Арга хэмжээ 2.6 Олон улсад гардаг станцуудын тоог нэмэгдүүлэх, холбогдох бэлтгэлийг хангах	Мэдээлэл гарсан байна.	63 өртөө олон улсын мэдээ солилцоон д гарч байна	27 шинээр бүртгүүлж нийт 90 өртөө	Өртөө шинээр хэрхэн бүртгүүлэх ДЦУБ-аас гаргасан заавар мэдээллийг судалсан. ДЦУБ-ын OSCAR/Surface платформд 75 өртөөдийн мета өгөгдлийг шинээр бүртгүүлж 11 дүгээр сарын 15-наас олон улсын мэдээ солилцоонд улсын сүлжээний бүх өртөө буюу 138 өртөөдийн мэдээ гарч эхэлсэн.	5-11	100

ХОЁР. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
15	Арга хэмжээ 2.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж ажлын гүйцэтгэлийг тайлагнах, дүгнүүлэх	Төлөвлөгөө боловсруулах, тайлан дүгнүүлэх	2024 он	Хугацаандаа төлөвлөгөө батлуулж, тайлагнаж, дүгнүүлэх	Хугацаандаа төлөвлөгөө батлуулж, тайлагнаж, дүгнүүлсэн.	1, 6, 12 сард	100
16	Арга хэмжээ 2.2 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах	Хугацаандаа өгөх		Хугацаандаа өгөх	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж ТАХаагчийн үүргээ биелүүлсэн.	1-2	100

17	Арга хэмжээ 2.3 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг мөрдөн ажиллах	Ёс зүйн зөрчилгүй байх		Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Ёс зүйн зөрчилгүй ажилласан.	1-12	
18	Арга хэмжээ 2.4 Удирдлагаас хуулийн хүрээнд өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг хэрэгжүүлэн ажиллах	Цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн байна.		Төрийн ажил тасралтгүй, чирэгдэлгүй явагдсан байх	Удирдлагаас өгсөн даалгаврыг цаг тухайд нь биелүүлсэн. Ирсэн 9 албан бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэж хаасан.	1-12	80
19	Арга хэмжээ 2.5 Хэлтсийн сар, улирал, жилийн тайлан мэдээг өөрийн хамаарах асуудлаар хуулийн хугацаанд гаргаж тайлагнах	Цаг тухайд нь		Цаг тухайд нь	Мэдээллийг цаг тухайд нь гаргаж хэлтсийн даргад тайлагнасан.	1-12	80

↓
 2019 (мөрөөлөл)
 асуулга
 зөв үүнийг
 бичих.

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Газрын үйл ажиллагаанд ISO9001 чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажилд оролцох	Сургалтад оролцсон байна.		Хичээлд бүрэн сууна	<p>Газрын даргын ...тоот тушаалаар Тус байгууллагад "ISO9001 чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх" ажлын хэсэгт орсон. 1 дүгээр сарын 20-ноос эхлэн Лхагва гараг бүрт ISO9001 чанарын менежментийн тогтолцооны тухай хичээлд бүрэн суусан. Дотоод аудитын 3 өдрийн сургалтад хамрагдсан. Хичээлээр стандартын ойлголт, хэрэглээ, үр дүн, ач холбогдолыг сайн ойлгосон. Цаашид, мэдлэгээ бусадтай хуваалцаж, өөрийн ажилд хэргжүүлэх, байгууллагад нэвтрүүлэх ажилд идэвхтэй оролцоно.</p> <p>Дээрх сургалтын чанарт хяналт тавих ажлын хэсгийн Нарийн бичгийн өгсөн хуулийн нийцлийн үнэлгээ, Хэлтсийн процесс зураглал гаргасан. Байгууллагад дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсэг /А65 тушаал/ 3 удаа хийсэн ажлын хэсгийн бүрэлдхүүнд оролцсон. Шалгалтаар илэрсэн Үл тохиролыг арилгах ажилд оролцсон.</p>	1-5	100

2	Арга зүйн зөвлөл/АЗЗ/, ажиллагаан оролцох	АЗЗ-ийн Хуралдаан зохион байгуулсан эсэх	2024 онд 1 удаа	Тухай бүрт	АЗЗ-д УЦУОСМХ-ийн 1/31 тоот албан тоот хүлээн авч Гишүүдэд мэдээлэл, нэмэлт танилцуулгыг хүргүүлэх, хуралдааныг товлох ажлыг зохион байгуулсан. 5 дугаар сарын 2-ны хуралдаанаар 2 асуудал хэлэлцсэн. Аудио бичлэгээс хуралдааны тэмдэглэл бичиж, гарын үсгээр баталгаажуулсан. Хуралдааны шийдвэрийг АЗЗ-ийн дарга болон Газрын даргад танилцуулсан. АЗЗ-ийн шийдвэрийн дагуу ЦД-1 цахим дэвтэр турших тухай тушаалын төсөл боловсруулж Газрын даргын А/88 тушаал батлуулсан.		100
3	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	Худалдах авах ажиллагаанд оролцоно.	2024 онд 4 тендерт нарийн бичиг	Тухай бүрт	“Цаг уур, хөдөө аж ахуйн багаж хэрэгсэл худалдан авах” нээлттэй Тендерийн баримт бичиг боловсруулж, хурал зохион байгуулж, тендерийн баримт бичиг батлуулсан. 2 удаа /6 дугаар сарын 26, 8 дугаар сарын 15/ зарласан, Шаардлага хангасан тендерийн материал ирүүлээгүй тул татгалзсан. Төсөв буцааж татагдсан тул дахин зарлаагүй. “Төв орон нутгийн интернет үйлчилгээ”-ний нээлттэй тендерийг хянаж, үнэлэж, захиалагчид зөвлөмж, оролцогчдод гэрээ байгуулах болон татгалзсан мэдэгдэл тус тус хүргүүлсэн. Нийт 2 тендерийн баримт бичиг, хурлын тэмдэглэл 4, зөвлөмж 3, мэдэгдэл 6 тус тус боловсруулсан.		100
4	Арга хэмжээ 9.3 Худалдах авах ажиллагаа болон АЗЗ-ийн хадгаламжийн нэгж үүсгэж архивт хүлээлгэн өгөх	Архив хүлээлгэн өгсөн байна.	2023 оны хадгаламж	4 архивын хадгаламжийн нэгж	Худалдан авах ажиллагааны 2024 оны 4, 2025 оны 1 тендерийн хадгаламжийн нэгжийг, Арга зүйн зөвлөлийн 2023-2024 оны 2 хадгаламжийн нэгжийг тус тус архивын мэргэжилтэнд бэлтгэж хүлээлгэн өгсөн.	3-5 сар	100

5	Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг /A187/	Хөгжлийн төлөвлөгөөний төсөл гарна		Ажлын хэсгийн саналыг нэгтгэж ажлын хэсгийн даргад хүргүүлнэ.	Ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэж ажлын хэсгийн даргад хүргүүлсэн. Хөгжлийн төлөвлөгөөний төслийг яам руу хүргүүлсэн.	10-12	
---	---	------------------------------------	--	---	---	-------	--

ГУРАВ. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. ЦУОШГ-ын болон бусад сургалт, хэлэлцүүлэг, семинарт оролцох	Оролцсон сургалтын тоо		Тухай бүрт оролцох	Дотоод аудитын 3 өдрийн сургалтад хамрагдаж амжилттай төгсөж сертификат авсан. Хуулбар хавсаргав.	1-6	100
3	Монгол бичгийн анхан шатны цахим сургалт	Цахим сургалт, сертификат авах		Сертификет авах	Монгол улсын Хөгжлийн хөтөлбөрт монгол бичиг төрийн албан бичиг болох тул Төрийн албан хаагчдыг монгол бичгээр уншуулж, бичүүлж сургах 8 цагийн цахим сургалтад хамрагдаж амжилттай төгсөж сертификат авсан. Анхан шатны унших чадвар олж авсан.	9	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах мэргэжилтэн

Амгалан АМГАЛАН/

2025-12-10

УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН НИСЛЭГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУРЫН УЛСЫН СҮЛЖЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.АМГАЛАНГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

Нэгжийн нэр: УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
НЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
Зорилт 1. Улсын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, хяналт тавих					
1	Арга хэмжээ 1.1 Хөдөө аж ахуйн цаг уурын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах арга хэмжээг авах, хяналт тавих	60	10	70	64
2	Арга хэмжээ 1.2 Хөдөө аж ахуйн цаг уур, нислэгийн 2026 оны дэвтэр, хүснэгтийн захиалга, хуваарь гаргаж батлуулах, хүлээн авах	60	10	70	70
3	Арга хэмжээ 1.3 Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын болон аэрологийн шинжилгээний ажлын хөтөлбөрт өөрчлөлт оруулж, шинэчилсэн төслийг боловсруулж, батлуулах	60	10	70	64
4	Арга хэмжээ 1.4 Нарны цацрагийн ажиглалтын сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах, хяналт тавих	60	10	70	58
5	Арга хэмжээ 1.5 Аэрологийн шинжилгээний өртөө байгуулах ажлыг Өвөрхангай, Говь-Алтай аймагт зохион байгуулж, хяналт тавих, зарцуулалтын тайлан нэгтгэх	60	10	70	70
6	Арга хэмжээ 1.6 Судалгаа, бэлтгэл ажил, Мета мэдээллийн жагсаалт гаргах	60	10	70	70
7	Арга хэмжээ 1.7 Хөдөө аж ахуйн салбарын Мэргэшлийн 1, 2, 3-р зэргийн шалгалтын асуултууд бэлтгэх, ажлын хэсгийн хуралдаанд оролцох	60	10	70	58
8	Арга хэмжээ 1.8 Олон улсын нислэгийн ИCAO-ийн шалгалтын бэлтгэл ажил хангах ажлыг зохион байгуулах	60	10	70	52

Зорилт 2. ДЦУБ-ын ажиглалтын WIGOS/OSCAR/Surface сүлжээнд цаг уурын ажиглалтын бүх өртөөний мета өгөгдлийг оруулж шинэчлэх					
9	Арга хэмжээ 2.1 Мета өгөгдлийн уур амьсгалын ангилалыг Коппены аргаар тодорхойлох	60	10	70	58
10	Арга хэмжээ 2.2 Уур амьсгал /УА/-ын ангилалыг бүх өртөө, харуулаар гаргах	60	10	70	58
11	Арга хэмжээ 2.3 Коппены ангилалаар тархалтын зураг гаргах	60	10	70	52
12	Арга хэмжээ 2.4 Цаг уурын өртөө, харуулын мета мэдээллийг үүсгэх	60	10	70	70
13	Арга хэмжээ 2.5 Орон нутгийн мэдээлэл үйлчилгээний ажлын хагас болон жилийн тайланг авч дүгнэх	60	10	70	70
14	Арга хэмжээ 2.6 Олон улсад гардаг станцуудын тоог нэмэгдүүлэх, холбогдох бэлтгэлийг хангах	60	10	70	70
ХОЁР. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ”					
ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
15	Арга хэмжээ 2.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж ажлын гүйцэтгэлийг тайлагнах, дүгнүүлэх	60	10	70	70
16	Арга хэмжээ 2.2 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах	60	10	70	70
17	Арга хэмжээ 2.3 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг мөрдөн ажиллах	60	10	70	70
18	Арга хэмжээ 2.4 Удирдлагаас хуулийн хүрээнд өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг хэрэгжүүлэн ажиллах	60	10	70	58
19	Арга хэмжээ 2.5 Хэлтсийн сар, улирал, жилийн тайлан мэдээг өөрийн хамаарах асуудлаар хуулийн хугацаанд гаргаж тайлагнах	60	10	70	58
НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ					
20	Газрын үйл ажиллагаанд ISO9001 чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажилд оролцох	60	10	70	70
21	Арга зүйн зөвлөл/АЗЗ/, ажиллагаан оролцох	60	10	70	70
22	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	60	10	70	70

23	Арга хэмжээ 9.3 Худалдах авах ажиллагаа болон АЗЗ-ийн хадгаламжийн нэгж үүсгэж архивт хүлээлгэн өгөх	60	10	70	70
24	Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг /А187/	60	10	70	70
Дундаж оноо:					65

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
	1	2	3	4	
1	ЦУОШГ-ын болон бусад сургалт, хэлэлцүүлэг, семинарт оролцох				
2	Монгол бичгийн анхан шатны цахим сургалт				
Дундаж оноо					15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
	1	2	3	
1.	Хандлага, ёс зүй			
2.	Дүн шинжилгээ хийх			
3.	Асуудал шийдвэрлэх			
4.	Хариуцлагатай байдал			
5.	Ажлын цаг ашиглалт			
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)				
6.	Мэргэжлийн ур чадвар 1.			
7.	Мэргэжлийн ур чадвар 2.			
8.	Мэргэжлийн ур чадвар 3.			
Дундаж оноо				6,8

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	
2.	Багаар ажиллах	
3.	Харилцаа	
Дундаж оноо		

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	65
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15

3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	68
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		94,8

Үнэлгээ өгсөн:

Улсын сүлжээний газрын дарга




Д.УЛАМБАЯР

2025 оны 12 дугаар сарын-ны өдөр

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Улсын сүлжээний газрын нислэг, хөдөө аж ахуйн цаг уурын улсын сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн



Г.АМГАЛАН

2025 оны 12 дугаар сарын-ны өдөр

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Хяналт, шинжилгээ дотоод аудитын
Хэлтсийн дарга



Х.ОЮУНБИЛЭГ

2025 оны 12 дугаар сарын-ны өдөр

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Захиргааны хэлтсийн хүний
нөөцийн асуудал хариуцсан
Ахлах мэргэжилтэн



Ж.ЭНХЧИМЭГ

2025 оны 12 дугаар сарын-ны өдөр

Үнэлгээг баталгаажуулсан:

Цаг уур, орчны шинжилгээний
Газрын дарга



Э.БАТТУЛГА

2025 оны 12 дугаар сарын-ны өдөр

